

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/03/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Н.АНХБАЯР ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр А корпус 3 давхар,
Мөрөн сум Хөвсгөл аймаг 67120
Утас/факс 7038 3793 Цахим шуудан khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас www.audit.mn

2024.03.25 № 01/268
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ТТЗ-ийн хяналтад байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 21.3 сая төгрөг, шилжүүлэн авсан 249.8 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 19.1 сая төгрөг, бусад эх үүсвэрээс хүлээн авсан 12.5 сая төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэж үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Цэцэрлэг сумын ТТЗ нь Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь 35.1 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 122.6 сая төгрөгөөр тасалсан, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 22 иргэнтэй холбоотой 51.7 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулаагүй зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Цэцэрлэг сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 8 зорилтын 84 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 72.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

5724040669

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/Мянган төгрөгөөр/	
			2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		672,825.0	939,158.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	422,108.9	540,211.9
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	115,912.0	197,137.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	134,804.1	201,809.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		6,109,150.3	5,901,551.6
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	87,900.0	87,512.5
37300	Урт хугацаат зээл		87,900.0	87,512.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	6,021,250.3	5,814,039.1
39200	Биет хөрөнгө		5,373,522.3	5,166,826.1
39300	Биет бус хөрөнгө	13	647,728.0	647,177.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		6,781,975.2	6,840,709.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		16,799.9	73,504.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	16,799.9	73,504.0
41300	Өглөг	17а, 17б	16,799.9	73,504.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,765,175.3	6,767,205.9
51	Засгийн газрын хувь оролцоо		6,765,175.3	6,767,205.9
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,105,063.2	1,105,063.2
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		4,265,341.8	4,285,291.8
51200	Хуримтлагдсан үр дүн		901,300.4	883,380.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		493,469.9	493,469.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		6,781,975.2	6,840,709.9

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/Мянган төгрөгөөр/	
		2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,171,913.2	1,779,200.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	568,948.5	570,396.7
110	Орлогын албан татвар	366,945.8	403,871.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	387,749.2	433,315.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20,803.4	-29,443.5
113	Хөрөнгийн албан татвар	74,802.8	78,437.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	127,199.9	88,087.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-454,853.8	-156,479.3
120	Нийтлэг татварын бус орлого	-454,853.8	-158,079.3
121	Хөрөнгийн орлого	0.0	1,600.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,057,818.6	1,365,283.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,418,428.7	1,618,990.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,418,428.7	1,618,990.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,370,115.4	1,141,094.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,084.9	509,732.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,559.8	63,081.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,437.5	14,485.3
2104	Хангамж, бараа материалын зардал	448,343.0	125,971.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,123.0	12,555.2
2107	Томилолт, зочны зардал	3,441.8	3,584.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,749.4	111,131.8

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	206,375.9	300,553.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,313.4	477,896.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-246,515.5	160,209.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,392,890.3	51,057.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-5,639,405.8	109,152.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/Мянган төгрөгөөр/	
		2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,746,167.7	2,334,274.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	568,948.5	570,396.7
110	Орлогын албан татвар	366,945.8	403,871.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	387,749.2	433,315.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20,803.4	-29,443.5
113	Хөрөнгийн албан татвар	74,802.8	78,437.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	127,199.9	88,087.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,907.1	11,998.2
1181	Газрын төлбөр	10,360.3	8,408.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	108,932.5	67,680.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	113,549.4	398,594.4
120	Нийтлэг татварын бус орлого	113,549.4	396,994.4
121	Хөрөнгийн орлого	0.0	1,600.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,063,669.8	1,365,283.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,848,412.2	2,157,158.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,848,412.2	2,157,158.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,167,169.2	1,722,218.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	566,819.9	703,413.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,400.7	119,809.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110,286.9	75,420.0
2104	Хангамж, бараа материалын зардал	182,712.6	144,799.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,452.0	19,265.6
2107	Томилолт, зочны зардал	3,441.8	3,584.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,008.3	578,428.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,047.1	77,498.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	681,243.0	434,940.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-102,244.5	177,115.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	131,973.5	59,012.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	131,973.5	59,012.6
2200	Дотоод эх үүсвэрээр	131,973.5	59,012.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-131,973.5	-59,012.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-87,900.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	87,900.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-322,118.0	118,103.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	744,226.9	422,108.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	422,108.9	540,211.9

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,379,716.6	0.0	11,379,716.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-66,112.5	0.0	-66,112.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,313,604.1	0.0	11,313,604.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	3,542.2	0.0	3,542.2
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	612,950.0	0.0	612,950.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	474,484.8	0.0	474,484.8
9	Тайлант үеийн үр дүн	-5,639,405.8	0.0	-5,639,405.8
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,765,175.3	0.0	6,765,175.3
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,765,175.3	0.0	6,765,175.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,765,175.3	0.0	6,765,175.3
17	Өмчид гарсан өөрчлөлт	19,950.0	0.0	19,950.0
19	Тайлант үеийн үр дүн	-17,919.5	0.0	-17,919.5
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,767,205.9	0.0	6,767,205.9

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,203,023.2	1,752,276.0	450,747.2	79.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,074,650.4	1,717,856.1	356,794.3	82.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,418,520.5	1,295,286.7	123,233.8	91.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	548,688.9	508,402.1	40,286.8	92.7
210101	Үндсэн цалин	417,321.3	360,240.8	57,080.5	86.3
210102	Нэмэгдэл	98,095.0	110,154.3	-12,059.3	112.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	5,110.0	-5,110.0	
210104	Урамшуулал	33,272.6	32,897.0	375.6	98.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,526.7	63,081.1	6,445.6	90.7
210201	Тэтгэврийн даатгал	47,579.0	43,590.2	3,988.8	91.6
210202	Тэтгэмжийн даатгал	5,486.9	5,124.9	362.0	93.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,389.6	4,060.3	329.3	92.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,097.4	933.4	164.0	85.1
210205	Эрүүл мэндийн даатгал	10,973.8	9,372.3	1,601.5	85.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	498,892.1	482,518.9	16,373.2	96.7
210301	Гэрэл, цахилгаан	33,868.5	30,395.4	3,473.1	89.7
210302	Түлш, халаалт	441,269.9	427,328.9	13,941.0	96.8
210303	Цэвэр, бохир ус	23,753.7	24,794.6	-1,040.9	104.4
2104	Хангамж, бараа материалын зардал	70,825.2	65,152.8	5,672.4	92.0
210401	Бичиг хэрэг	3,800.0	3,895.4	-95.4	102.5
210402	Тээвэр, шатахуун	47,500.0	44,181.5	3,318.6	93.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,240.0	2,658.6	1,581.4	62.7
210404	Ном, хэвлэл	864.6	635.9	228.7	73.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200.0	200.0	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,220.6	13,581.5	639.1	95.5

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,511.2	76,231.1	6,280.1	92.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,300.0	9,279.9	5,020.1	64.9
210604	Урсгал засвар	68,211.2	66,951.2	1,260.1	98.2
2107	Томилолт, зочны зардал	4,000.0	3,584.0	416.0	89.6
210702	Дотоод албан томилолт	4,000.0	3,584.0	416.0	89.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,833.9	50,992.2	41,841.7	54.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,733.9	49,766.4	39,967.5	55.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400.0	0.0	400.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	100.0	100.0	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400.0	400.0	0.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100.0	99.1	0.9	99.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600.0	600.0	0.0	100.0
210807	Газрын төлбөр	1,500.0	26.7	1,473.3	1.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,242.5	45,324.5	5,918.1	88.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,000.0	22,276.0	3,724.0	85.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,242.5	23,048.5	2,194.1	91.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	656,129.9	422,569.4	233,560.6	64.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	608,827.7	414,010.0	194,817.7	68.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	608,827.7	414,010.0	194,817.7	68.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,302.2	8,559.4	38,742.9	18.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,502.2	0.0	32,502.2	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,800.0	8,559.4	6,240.7	57.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,002.0	34,419.9	3,582.1	90.6
223001	Бусад хөрөнгө	38,002.0	34,419.9	3,582.1	90.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	90,370.8	0.0	90,370.8	0.0
230001	Эргэж төлөгдөх зээл	90,370.8	0.0	90,370.8	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,203,023.2	1,880,462.2	322,561.0	85.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	459,327.7	451,327.7	8,000.0	98.3
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	459,327.7	451,327.7	8,000.0	98.3
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,384,816.1	1,402,781.6	-17,965.5	101.3
320001	Орон нутгийн төсвөөс	1,384,816.1	1,402,781.6	-17,965.5	101.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	358,879.4	26,352.9	332,526.5	7.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,370.8	22,365.0	68,005.8	24.7
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	556.2	3,987.9	-3,431.7	717.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	267,952.4	0.0	267,952.4	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	145,776.2	-145,776.2	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	273,962.5	-273,962.5	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	58.00	58.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	28.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	11.00	11.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.00	28.00	0.00	100.0

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00	0.00	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	10.00	10.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,425.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,425.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,525.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,330.0
210104	Урамшуулал	1,330.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,712.5
210402	Тээвэр, шатахуун	2,942.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,770.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,083.0
210604	Урсгал засвар	4,083.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,400.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	900.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	900.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,425.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,425.5
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,120.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,305.0

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 1 аж ахуй нэгж, 2 тусгай сан нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сан түүвэрт хамрагдаж, 1 аж ахуй нэгжид дүгнэлт гаргасан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт 209.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг өгсөн.

Цэцэрлэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 21.9 сая төгрөгийн алдаа, 73.5 сая төгрөгийн зөрчил, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 90.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Аудитын явцад 21.9 сая төгрөгийн алдааг залруулж 15.6 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 148.1 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмжийг өгсөн байна.

Цэцэрлэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 15.6 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн бөгөөд тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өгсөн болно.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 22 иргэнтэй холбоотой 51.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах

2. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Малд ногдуулах албан татварын орлого 20.9 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 1.5 сая төгрөгөөр, Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 11.4 сая төгрөгөөр, Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 0.4 сая төгрөгөөр, Хувьцааны ногдол ашиг 1.0 сая төгрөгөөр нийт 35.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 51.4 сая төгрөгөөр, дотоодын бараа үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 71.2 сая төгрөгөөр нийт 122.6 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх.

3. Байгууллагын эзэмшил газартай холбоотой асуудал

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын эзэмшилд байгаа газрын талаар судалгаа авч горим сорил хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудал илэрсэн. Үүнд:

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

- Цэцэрлэг сумын ЗДТГ-ын эзэмшил газраас ардчилсан намд 287 м.кв,
- ЗДТГ-ын буудлын эзэмшил газраас Монгол ардын намд 95.6 м.кв,
- ЗДТГ-ын 2 айлын орон сууцны газрыг хувааж 781.3 м.кв талбайг гэр бүлийн хэрэгцээнд иргэнд эзэмшүүлсэн.

Дээрх зөрчил нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.Энэ хуулийн 35.1.4, 35.1.6-д заасан эрх төрийн байгууллагад хамаарахгүй гэсэн заалт болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшил газрыг хувааж бусдад эзэмшүүлсэн эрх зүйн актыг цуцалж газрыг ЗДТГ-ын эзэмшилд шилжүүлэх.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Запруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Харьяа байгууллагуудын алдаа Тэсийн-Илч ХХК								
Бүртгэл тайлагналын алдаа	1	21.9	1	21.9			1	21.9

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	157.7					1	157.7				
Хугацаа хэтэрсэн зээлийн авлага	1	51.0					1	51.0				
Дүн	2	209.3					2	209.3				
Харьяа байгууллагуудын зөрчил /ЗДТГ/												
Тайлант онд дотоод хяналтын төлөвлөгөө батлуулж хяналт хийж ажиллаагүй	1						1					
Хөрөнгө оруулалтын зардалд урсгал зардал, болон хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийг баталж зарцуулсан	1	34.4					1	34.4				
Тус байгууллагын дансанд хувь хүмүүсээс авах авлагыг барагдуулаагүй	1	13.3					1	13.3				
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал												
Төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах	1	15.4	1	15.4								

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

арга хэмжээнд илүү зардал гаргасан											
Тэсийн-Илч ХХК											
Ажил эрхлээгүй ажилтныг НДШ-ийн тайланд тайлагнасан	1	0.2	1	0.2							
Худалдан авалттай холбоотой цахим и-баримтгүй гүйлгээ хийсэн	1	10.2					1	10.2			
Дүн	2	10.4	1	0.2			1	10.2			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Харьяа байгууллагуудын зөрчил /ЗДТГ/								
Газрыг хувааж бусдад эзэмшүүлсэн	1						1	
Тэсийн-Илч ХХК								
Шилэн дансны мэдээлэл	1	90.2						

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	2	1	1		1			
2	Төсөл, хөтөлбөр	2		2					
3	ТБОНӨААН	1	1			1			
4	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	6	3	3		3			